



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/69

Арвайхээр

Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. МММ констракшн ХХК, Хүлгийн дээд ХХК, иргэн Ч.Чинзориг нарын гаргасан хүсэлтийн дагуу 13 дугаар баг Т.Намнансүрэнгийн 7 дугаар гудамжинд байрлах нийтийн орон сууцны зориулалттай тус бүр 1600 м² газрын, BALDAN'S ХХК-ийн эзэмшил Т.Намнансүрэнгийн 1 дүгээр гудамжинд байрлах нийтийн орон сууцны зориулалттай 1000 м² газрын, Аймгийн ХХААЖДҮГазар (хуучин нэрээр)-ын эзэмшил Мал эмнэлгийн хойно байрлах 2500 м² газрын, Голомт банкны Өвөрхангай салбарын эзэмшил Шинэ Арвайхээрийн төвд байрлах банкны оффисын зориулалттай 3000 м² газрын, Т.Намнансүрэнгийн 3 дугаар гудамжинд байрлах иргэн Д.Баяртогтохын эзэмшил гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 300 м² газрын, Жигүүр-Оргил ХХК-ийн эзэмшил 8 дугаар баг 11 дүгээр гудамжны урд байрлах нийтийн орон сууцны зориулалттай 324 м² газрын, иргэн Ж.Самданжигмэдийн эзэмшил Худалдааны тойруу 334 тоотод байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай 400 м² газрын, иргэн Ц.Мягмарсүрэнгийн эзэмшил 7 дугаар баг 10 дугаар гудамжны зүүн талд байрлах Усан сангийн зориулалттай 25 м² газрын эзэмших эрхийг тус тус хүчингүй болгосугай.

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2015 оны а/557 дугаар захирамжийн МММ констракшн ХХК, Хүлгийн дээд ХХК, 2018 оны а/556 дугаар захирамжийн иргэн Ч.Чинзоригтой холбогдох заалт, 2008 оны 98 дугаар захирамжийн BALDAN'S ХХК-нд холбогдох заалт, 2012 оны а/327 дугаар захирамжийн Аймгийн ХХААЖДҮГазар (хуучин нэрээр)- т холбогдох заалт, 2013 оны а/384 дүгээр захирамжийн Голомт банктэй холбогдох заалт, 2009 оны 408 дугаар захирамжийн иргэн Д.Баяртогтохтой холбогдох заалт, 2013 оны а/439 дүгээр захирамжийн Жигүүр-Оргил ХХК-нд холбогдох заалт, 2018 оны а/476 дугаар захирамжийн иргэн Ж.Самданжигмэдэд холбогдох заалт, 2011 оны 19 дүгээр захирамжийн иргэн Ц.Мягмарсүрэнд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Газрыг төрийн мэдэлд авч, газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулж, ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100149